



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 09 сарын 26 өдөр

Дугаар A/52

Улаанбаатар хот

Г Дотоод хяналт шалгалт зохион  
байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/727 дугаар захирамж, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Хэлтсүүдийн дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, хяналт шалгалтын удирдамжийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг зохион байгуулж, үр дүнг газрын Удирдлагын зөвлөлийн хуралд 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг (Г.Энхээ)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э.Даваахатан)-т даалгасугай.

ДАРГА

С.ТӨМӨРДУЛАМ

